



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нийцлийн аудитын тайлан

ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ БҮРЭН ХАНГАГДААГҮЙ БАЙНА

2025 оны 05
дугаар сар

АУДИТЫН СЭДЭВ: ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ж.Айгүл

Утас: 70422954 Цахим хаяг: Aigulj@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn

Ахлах аудитор: С.Нурлан

Утас: 99103281 Цахим хаяг: nurlans@audit.gov.mn

Аудитор: Х.Манаргүл

Утас: 95429524 Цахим хаяг: manargulkh@audit.gov.mn

2025 он

АГУУЛГА

АГУУЛГА	2
Товчилсон үгийн тайлбар	3
Хүснэгтийн товъёг.....	4
Графикийн товъёг.....	4
Хавсралтын товъёг	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	5
А. ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ БҮРЭН ХАНГАЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА	7
А.1. Хуулийн 5-12 дугаар зүйлийг зохих түвшинд хэрэгжүүлж ажилласан байна.....	7
А.2.Төсвийн байгууллагууд төрийн хэмнэлтийн бусад арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж ажиллаагүй байна	10
Б.ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТАЙ ХОЛБООТОЙ ХУУЛЬД ЗААСАН ЖУРМЫГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАСАН БОЛОВЧ ЦАХИМ ХУДАЛДАН АВАЛТЫН ЖУРМЫН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА	17
Б.1.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийг хэрэгжүүлэн ажилласан байна	17
Б.2.Цахим худалдан авах ажиллагааг хуульд заасан журмын дагуу зохион байгуулж ажиллаагүй байна.....	19
В.ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТАЛААР ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ ҮР ДҮН БАГАТАЙ БАЙНА	22
В.1.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд дотоод аудитыг үр нөлөөтэй чиглүүлж ажиллаагүй байна	22
В.2. Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажилласан боловч үр дүн багатай байна	24
В.3. Шилэн дансны хуулийг зарим байгууллага бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна	26
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ	28
ДҮГНЭЛТ:	29
1.Орон нутгийн байгууллагууд хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллаагүй байна.....	29
2.Төрийн цахим худалдан авалтын хэрэгжилт хангалтгүй байна.	29
3.Дотоод аудитыг үр нөлөөтэй хэрэгжүүлж ажиллаагүй байна.....	29
ЗӨВЛӨМЖ:	30
I.Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэст:	30
II.Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албад:	30
III.Аймгийн Худалдан авах ажиллагааны газарт:	30
ҮАГ-т уламжлах санал :	30
ХАВСРАЛТ:1	32

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дэд байгууллагын олон улсын стандарт
ТАХ	Төсөл арга хэмжээ
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үзүүлэлт
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөө бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ҮАГ	Үндэсний аудитын газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ТХтХ	Төрийн хэмнэлтийн тухай хууль
УБ	Улаанбаатар
ЦШСГ	Цахилгаан шугам сүлжээний газар
НААҮ	Нийтийн аж аухйн үйлчилгээ
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт

Хүснэгтийн товьёг

Хүснэгт 1	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4-12 дугаар зүйлийн хэрэгжилтийн талаарх судалгаа	7
Хүснэгт 2	Санхүүгийн 2022-2024 оны тайлангийн аудитаар ТХтХуулийн 5-12 дугаар зүйлтэй холбоотой гарсан зөрчлийн талаарх судалгаа	8
Хүснэгт 3	Санхүүгийн тайлангийн болон нийцлийн аудитад хамрагдсан 2023-2024 оны зөрчлийн судалгаа	10
Хүснэгт 4	Байр ашиглалттай холбоотой зардлын судалгаа /2023/	12
Хүснэгт 5	Өлгий сумын энгийн галлагаатай сургуулиудын судалгаа	13
Хүснэгт 6	<i>Нэгдсэн халаалтын системд холбогдсон байгууллагуудын түлш халаалтын зардлын судалгаа</i>	13
Хүснэгт 7	<i>ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын зарим зардлуудын судалгаа</i>	14
Хүснэгт 8	Өглөгийн дэлгэрэнгүй судалгаа /2022-2024/	15
Хүснэгт 9	Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээг худалдан авах ажиллагааны талаарх судалгаа	18
Хүснэгт 10	Цахим худалдан авах авалтай холбоотой илэрсэн зөрчлийн судалгаа	19
Хүснэгт 11	Аудитаар илэрсэн зөрчлийн талаах судалгаа /цахим худалдан авалт хийгдээгүй хөрөнгийн ангилж харуулсан судалгаа /	21
Хүснэгт 12	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой гарсан зөрчлийн нэгтгэл	22
Хүснэгт 13	Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой гарсан зөрчлийн нэгтгэл	26

Графикийн товьёг

График 1	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4-12 дугаар зүйлийн хэрэгжилтийн талаар	15
----------	---	----

Хавсралтын товьёг

Хавсралт 1	Төрийн аудитын газраас 2022-2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар болон Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт үр дүнд хийгдсэн нийцлийн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	31
------------	---	----

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1.10-т заасан бүрэн эрхийн хүрээнд, Монгол улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны 2024 оны “Аудитын сэдэв батлах тухай” 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2024 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/108 дугаар тушаал, Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хийж гүйцэтгэв.

Аудитын зорилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүнд нийцлийн аудит хийж, дүгнэлт өгч зөвлөмж боловсруулан дүнг УИХ болон холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэхэд аудитын зорилго чиглэгдэв. Уг зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэнэ. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж ажилласан уу;
- Хөрөнгө оруулалттай холбоотой хуульд заасан журмыг хэрэгжүүлж ажилласан уу;
- Засгийн газар болон төрийн байгууллагаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ үр дүнтэй байсан уу;

Аудитын хамарсан хүрээ

Аудитыг төсвийн байгууллага, орон нутгийн өмчийн аж ахуйн нэгжүүдийн 2022, 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг уялдуулан, Төсвийн ерөнхий захирагч, тэдгээрийн харьяа байгууллагууд, ОНӨҮГ-ын 2024 оны санхүүгийн үйл ажиллагааг түүвэрт хамруулж холбогдох баримт материалын хүрээнд хийж гүйцэтгэв.

Аудитын хязгаарлалт

Хууль, хяналтын байгууллага болон шүүхээр хянан хэлэлцэгдэж буй асуудлыг аудитад хамруулаагүй болно.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитыг АДБОУС 100, 400, 4000-4200, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-4:2020, MNS 6817-6:2020 “Нийцлийн аудитын зарчим”, MNS 6817-8:2020 “Нийцлийн аудитын стандарт”, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ хийх, харьцуулах, тулган баталгаажуулах, түүвэрлэлт хийх зэрэг судалгааны арга зүйг ашиглав./Асуудлын шинжилгээг хавсралт №2, аудитын загварын матрицыг хавсралт №3-т үзүүлэв/

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл хянан удирдаж, аудитын менежер Х.Женисбек чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор С.Нурлан, аудитор Х.Манаргүл, В.Хуандаг, Б.Галымбек нар хамтран гүйцэтгэв.

Аудитын талбарын ажлыг 4 дүгээр сарын 01-нээс 5 дугаар сарын 02-ны дотор гүйцэтгэсэн ба тайлагналын үе шатны ажлыг 2025 оны 5 сарын 05-наас эхлүүлж, 5 сарын 12-ны хооронд хийж, 5 сарын 12-ны дотор Үндэсний аудитын газарт, 5 сарын 14-ны дотор холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ.

Хүндрэл бэрхшээл

Аудитын талбарын ажлыг санхүүгийн тайлангийн аудитын дараа богино хугацаанд төлөвлөж хэрэгжүүлсэн тул ачаалалтай ажилласан, хугацааны хувьд богино байв.

А. ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ БҮРЭН ХАНГАЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА**А.1. Хуулийн 5-12 дугаар зүйлийг зохих түвшинд хэрэгжүүлж ажилласан байна**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүн сэдвээр хийсэн нийцлийн аудитаар түүвэрт хамрагдсан 51 байгууллагаас хуулийн 4-12 дугаар зүйлийн хэрэгжилтийг шалгаж үзэхэд 8 байгууллагад хуулийн 4, 6, 8, 12 дугаар зүйлийн хэрэгжилттэй холбоотой 41.5 сая төгрөгийн зөрчилд 7 албан шаардлага хүргүүлэв.

Хүснэгт-1			/мянган төгрөг/			
Хуулийн заалтын хэрэгжилттэй холбоотой	ТХтХуулийн зүйл	Байгууллагын тоо	Албан шаардлага		Нийт	
			Тоо	Дүн	Тоо	Дүн
Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд баримтлах зарчмыг хэрэгжүүлж ажилласан эсэх	4-р зүйл	4	4	21,485.8	4	21,485.8
Тээврийн хэрэгслийн хязгаарлалтыг хэрэгжүүлж ажилласан эсэх	6-р зүйл	1	2	1,287.6	1	0
Дүрэмт хувцасны хязгаарлалтыг хэрэгжүүлсэн эсэх	8-р зүйл	1	0	5,000.0	0	5,000.00
Бусад хангамжийн зардлыг хэмнэсэн эсэх	12-р зүйл	2	1	13,680.6	2	14,967.6
Нийт		8	7	41,453.4	7	41,453.4

Эх сурвалж: Аудитын судалгаа

Аудитаар түүвэрт хамрагдсан 51 байгууллагын 84.3 хувь буюу 43 байгууллага хуулийн 5-12 дугаар зүйлийг мөрдөж ажилласан бол 15.7 хувь буюу 8 байгууллагаас хуулийн 6, 8, 12 дугаар зүйлтэй холбоотой зөрчил илэрсэн. Үүнд:

Хуулийн 4 дүгээр зүйл “Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд баримтлах зарчим”, 6 дугаар зүйл “Тээврийн хэрэгсэл”-ийн хязгаарлалттай холбоотой дараах зөрчил илэрсэн.

- Аймгийн Шүүх шинжилгээний хэлтсийн тээврийн хэрэгслийн 2023-2024 оны техникийн хяналт хоорондын гүйлтийг жолоочийн шатахуун зарцуулалтын тооцоогоор гарсан гүйлттэй тулган шалгахад 4404 БӨТ улсын дугаартай Ланд-80 маркийн автомашины спидометрийн заалт 19,246 км-ээр зөрүүтэй буюу 10.7 сая төгрөгийн, 9495 БӨА улсын дугаартай Фургон маркийн автомашины спидометрийн заалт 1,586 км-ээр буюу 0.9 сая төгрөгийн шатахууныг санхүүгийн хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар зарцуулж, тээврийн хэрэгслийн замын хуудсыг спидометрийн заалттай тулган хөтлөөгүй, шатахуун зарцуулалтад тавих хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн,

- Дарга нь хот дотор ажлаар 1,584 км-т 316 литр буюу 0.9 сая төгрөгийн, нягтлан бодогч нь санхүүгийн ажлаар 845 км-т 169 литр буюу 0.5 сая төгрөгийн, нярав жолооч нь аж ахуйн ажлаар 3,517 км-т 703 литр буюу 1.9 сая төгрөгийн нийтдээ 3.3 сая төгрөгийн шатахуун зарцуулсан.

- Аймгийн Эрүүл мэндийн газар “Nissan Patrol”, “Hanter”, суудлын автомашинаар 2024 онд хот дотор ажлаар 14 удаа 348 км буюу 1.3 сая төргийн шатахууныг зарцуулсан байна.

- Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалаар баталсан тээврийн хэрэгслийн 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг нормоор тооцож үзэхэд Аймгийн Байгаль орчны газар 100 км гүйлтэд зарцуулах шатахууныг тогтмол 20 литрээр бодож 2023-2024 онд 2.3 сая төгрөгийн, Онцгой байдлын газар “Land Gruiser-J200”, “Land Gruiser-J78L”, “Sonata-YF” суудлын автомашинд 2024 онд 2.6 сая төгрөгийн, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар “Land Gruiser-76” суудлын автомашинд 1.6 сая төгрөгийн шатахууныг нормоос илүү зарцуулсан, Шүүх шинжилгээний хэлтэс 100 км гүйлтэд зарцуулах шатахууныг тогтмол 20 литрээр бодож олгосон байна.

-Байгаль орчны газар УАЗ маркийн улсын 3771 БӨТ дугаар бүхий албаны авто машины улсын дугаарыг бусад автотээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаараар өөрчлөөгүй байна.

Хуулийн 8 дугаар зүйл “Дүрэмт хувцас”-ны хязгаарлалттай холбоотой дараах зөрчил илэрсэн.

- Өлгий сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал бараа үйлчилгээний бусад зардлын төсвөөс нормын хувцасны үнэд 5.0 сая төгрөг зарцуулсан.

Хуулийн 12-р зүйл “Бусад хангамж” хязгаарлалттай холбоотой дараах зөрчил илэрсэн.

- Өлгий сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал төлөөлөгчдийн монтажны үнэд 6.7 сая төгрөг, шинэ жилд 4.0 сая төгрөг, Өлгий-УБ-УБ-Эрдэнэт чиглэлийн хоёр талын унааны зардалд 3.0 сая төгрөг бүгд 13.7 сая төгрөг зарцуулсан.

Тус аудитын газраас 2022-2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар ТХтХуулийн 5-12 дугаар зүйлтэй холбоотой нийтдээ 66.9 сая төгрөгийн зөрчил илэрч 3.3 сая төгрөгийн 6 төлбөрийн акт, 57.6 сая төгрөгийн 3 албан шаардлага, 6.0 сая төгрөгийн 5 зөвлөмж өгсөн байна. Үүнд:

Хүснэгт-2			/мянган төгрөг/							
Хуулийн хэрэгжилт /зүйл, заалттай холбоотой/	Он	Байгууллагын тоо	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Нийт дүн	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
5-р зүйл, Тэргүүн дэд, дэд, орлогч дарга ажиллуулсан	2022	0							0	0
	2023	0							0	0
	2024	1					1	2570.3	1	2570.3
6-р зүйл, Тээврийн хэрэгслийн хязгаарлалтыг хэрэгжүүлж ажилласан	2022	1					1	0	1	0
	2023	2					2	0	2	0
	2024	0							0	0
11-р зүйл, Нэг удаагийн тэтгэмж	2022	4	2	2242.3	2	2110			4	4352.3
	2023	1					1	3432.4	1	3432.4

давхардуулан олгосон	2024	0						0	0
12-р зүйл, Бусад хангамжийн зардлыг хэмнэсэн	2022	1	1	195.0				1	195
	2023	1			1	55,526.0		1	55526
	2024	3	3	880.0				3	880
Нийт		14	6	3,317	3	57,636	5	6,003	66,956

Эх сурвалж: Аудитын судалгаа

Дээрх хүснэгтээс харахад 2022-2024 оны санхүүгийн тайлангийн аудитад хамрагдсан 255 байгууллагын 94.5 хувь буюу 241 байгууллага хуулийн 5-12 дугаар зүйлийг мөрдөж ажилласан бол 5.5 хувь буюу 14 байгууллагаас хуулийн 5, 6, 11, 12 дугаар зүйлийг зөрчсөн зөрчлүүд илэрсэн. Үүнд:

Хуулийн 5 дүгээр зүйл “Тэргүүн дэд, дэд, орлогч дарга” ажиллуулсан дараах байгууллагаас зөрчил илэрсэн байна.

- Алтай сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 11-ны өдрийн Б/06 дугаар захирамжаар Засаг даргын зөвлөхийн орон тоо бий болгож, төсвөөс цалингийн зардалд 2.5 сая төгрөгийг үр ашиггүй зарцуулсан.

Хуулийн 6 дүгээр зүйл “Тээврийн хэрэгсэл”-ийн хязгаарлалттай холбоотой дараах зөрчил илэрсэн.

- 2022 онд Аймгийн Эрүүл мэндийн газар нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6.3-р зүйлийг зөрчиж "Ниссан патрол", Пургон, Хантер маркийн бүгд 3 суудлын авто машин ашиглаж байна

- 2023 онд Аймгийн Нийтийн Номын сангийн Альфард маркийн 1765 БӨА дугаар бүхий машин, Баяннуур сумын Засаг даргын тамгын газрын УАЗ 469 маркийн улсын 0075 БӨТ дугаар бүхий албаны авто машины улсын дугаарыг бусад автотээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаараар өөрчлөөгүй байна.

Хуулийн 11 дүгээр зүйл “Нэг удаагийн тэтгэмж давхардуулан олгосон”-той холбоотой дараах байгууллагаас зөрчил илэрсэн байна.

- 2022 онд Аймгийн Дэлүүн сумын засаг даргын тамгын газар нь тэтгэвэрт гарсан Засаг даргын тамгын газрын дарга, жолооч нарт тэтгэвэрт гарахад нэг удаа олгох тэтгэмжийг олгосон боловч тайлант онд цалингийн зардлаас 1.6 сая төгрөгийн нэг удаагийн тэтгэмжийг давхар олгосон.

- 2022 онд Дэлүүн сумын ерөнхий боловсролын сургууль нь тэтгэвэрт гарсан няравт нэг сарын үндсэн цалинтай тэнцэх нэг удаагийн тэтгэмжийн олгосон.

- 2022 онд Ногооннуур сумын ерөнхий боловсролын нэг дүгээр сургууль нь тэтгэвэрт гарсан багшид тэтгэвэрт гарахад нэг удаа олгох тэтгэмжийг олгосон боловч мөнгөн тэтгэмжийг давхар олгосон, сургуулийн захирал буруу тушаал гаргаж 3 багшид урамшууллыг илүү олгосон

- 2022 онд Ногооннуур сумын Эрүүл мэндийн төв нь ахлах сувилагчаар ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэрт гарсан иргэнд тэтгэвэрт гарахад нэг удаа олгох тэтгэмжийг олгосон боловч мөнгөн тэтгэмжийг давхар олгосон

- 2023 онд Цэнгэл сумын Эрүүл мэндийн төв өндөр насны тэтгэвэрт гарсан ажилтнуудад 3.4 сая төгрөгийн нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгосон.

Хуулийн 12 дүгээр зүйл “Бусад хангамж”-ийн зардалтай холбоотой дараах байгууллагаас зөрчил илэрсэн байна.

- 2022 онд аймгийн Татварын газар төсвийн хөрөнгөөр тус байгууллагын үндсэн үйл ажиллагаанд хамааралгүй 150.0 мянган төгрөгийн ном, 45.0 мянган төгрөгийн сэтгүүл худалдан авсан байна.

- 2023 онд Орон нутгийн өмчийн газар 2023 онд үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөнөөс давсан 55.5 сая төгрөгийг нэмэлт дансанд төвлөрүүлж байгууллагын урсгал үйл ажиллагаанд зарцуулсан,

- 2024 оны Сагсай сумын Даян багийн ерөнхий боловсролын сургууль, Булган, Сагсай сумдын Соёлын төв албан хаагчдад 2024 онд 0.9 сая төгрөгийн гар утасны нэгжийн мөнгө олгосон.

А.2. Төсвийн байгууллагууд төрийн хэмнэлтийн бусад арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж ажиллаагүй байна

Санхүүгийн тайлангийн болон нийцлийн аудитад 2023-2024 онд хамрагдсан 11 байгууллагаас Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйл “Хэмнэлтийн бусад арга хэмжээ”-тэй холбоотой нийтдээ 144.5 сая төгрөгийн зөрчил илэрч 5 байгууллагад 9.3 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 8 байгууллагад 130.6 сая төгрөгийн зөрчил арилгах албан шаардлага, 3 байгууллагад 4.5 сая төгрөгийн зөвлөмж өгөгдсөн байна.

Хүснэгт-3			/Мянган төгрөг/							
Аудитын төрөл	Он	Байгууллагын тоо	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Нийт	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудит	2023	4	2	4263.1	2	9,145.0			4	13,408.1
Санхүүгийн тайлангийн аудит	2024	6			3	58,384.4	3	4,542.0	6	62,926.3
Нийцлийн аудит	2024	5	3	5119.9	3	63,082.4			6	68,202.3
Нийт		15	5	9,383.0	8	130,612.0	3	4,542.0	16	144,536.7

Эх сурвалж: Аудитаар илэрсэн зөрчлийн судалгаа

Нийцлийн аудитаар мөнгөн урамшууллыг хэтрүүлэн олгосон, байгууллагын төсвөөс төлсөн албан хаагчдын орон сууцны цахилгаан, дулаан, цэвэр усны төлбөрийг суутгаагүй зэрэг зөрчил гаргасан 3 байгууллагад 5.1 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 3 байгууллагад 63.1 сая төгрөгийн зөрчил арилгах албан шаардлага өгсөн. Үүнд:

- Аймгийн Байгаль орчны газар 2024 онд эрх бүхий байгууллагын албан тушаалтнаас мөнгөн урамшуулал олгох тухай шийдвэр гараагүй байхад 1.1 сая төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон, Хүнс, хөдөө аж ахуйн газар шинэ жилийн баяраар ажилтан, албан хаагчдад өвлийн өвгөн аавын бэлэг нэрээр 2.6 сая төгрөгийн гарын бэлэг олгосон, Шүүх шинжилгээний хэлтсийн барилгын 3 дугаар

давхарт амьдардаг 2 албан хаагчийн байрны халаалт, цэвэр бохир усны төлбөрт 1.4 сая төгрөгийг төсвөөс төлсөн бүгд 5.1 сая төгрөгийг нөхөн төлүүлэх акт тогтоов.

- Хүнс, хөдөө аж ахуйн газар төрийн захиргааны албан хаагчдад 5 жилд нэг удаа олгох тэтгэмжийн зардлаас нийгмийн даатгалын шимтгэлд 2.3 сая төгрөг төлсөн, аймгийн Засаг даргын 2024 оны “Мөнгөн урамшуулал олгох тухай” Б/21 дугаар захирамжаар 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд өөрчлөлтгүй дүгнэлт авсан гэж газрын даргад 2.0 сая төгрөгийн, ХХААГ-ын даргын 2024 оны А/20 дугаар тушаалаар няравт 1.6 сая төгрөгийн урамшуулал олгож, төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын хэмжээг хэтрүүлсэн,

- Өлгий сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал 21 аймгийн ИТХ-ын ажлын албаны чуулга уулзалт, бэлэг дурсгалд 3.0 сая төгрөг, ойн баяр, бусад арга хэмжээнд зориулан тэмдэг, өргөмжлөлийн үнэ 4.6 сая төгрөг бүгд 7.6 сая төгрөг зарцуулсан,

- Аймгийн Эрүүл мэндийн газар 2023 онд Аймгийн Засаг даргын 2019 оны А/751 дүгээр захирамжаар баталсан бүтэц орон тоонд тусгагдаагүй 2 орон тоо /Хууль эрх зүй, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн асуудал хариуцсан ажилтан, Эмнэлгийн тоног төхөөрөмж, засвар үйлчилгээ хариуцсан ажилтан/-г илүү баталж 2024 оны 11 дүгээр сар хүртэл ажиллуулан цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 14.3 сая төгрөг зарцуулсан,

Аймгийн Засаг даргын 2023 оны А/927 дугаар захирамжаар Эрүүл мэндийн газрын бүтэц, орон тоонд “Барилгын чанар, аюулгүй байдал, хэвийн үйл ажиллагаа, эмнэлгийн тоног төхөөрөмж, засвар үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн”-ий төрийн захиргааны орон тоо батлагдаж ажиллаж байхад Төрийн албаны тухай хуулийн дагуу сонгон шалгаруулалт явуулахгүйгээр “Эмнэлгийн тоног төхөөрөмж, засвар үйлчилгээ хариуцсан ажилтан”-ы орон тоонд төрийн үйлчилгээний ангиллаар 1 хүнийг 2024 оны 06 дугаар сарын 25-ний хүртэл давхар ажиллуулсан,

Аймгийн Засаг даргын 2024 оны А/971 дүгээр захирамжаар Эрүүл мэндийн газрын бүтэц, орон тоог 45-аар баталсан боловч Эрүүл мэндийн газрын даргын 2024 оны Б/35 дугаар тушаалаар аймгийн Засаг даргын захирамжаар батлагдаагүй дотоод аудит хариуцсан мэргэжилтэн, дүн бүртгэлийн операторчны 2 орон тоог илүү баталж ажиллуулан цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 35.1 сая төгрөг зарцуулсан, нийт 49.4 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

Хуулийн 15.2.1-д “байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх” гэсэн заалтын хэрэгжилтийг шалгаж үзэхэд:

Баян-Өлгий аймгийн төсвийн ерөнхий захирагчийн харьяа орон нутгийн байгууллагуудын байр ашиглалттай холбоотой /цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр ус/ тогтмол зардлын төсөв 2023 онд 227.3 сая төгрөгөөр, 2024 онд 1,500.7 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна.

Хүснэгт-4		/ мянган төгрөг /		
Он	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
2023	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,395,644.3	10,168,385.0	(227,259.3)
	Гэрэл цахилгаан	567,462.4	545,781.3	(21,681.1)
	Түлш халаалт	9,137,539.0	8,946,777.9	(190,761.1)
	Цэвэр, бохир ус	272,988.0	265,717.1	(7,270.9)
	Байрны түрээс	417,654.9	410,108.7	(7,546.2)
2024	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,186,694.8	13,685,990.0	(1,500,704.8)
	Гэрэл цахилгаан	948,731.0	932,942.7	(15,788.3)
	Түлш халаалт	12,779,575.1	11,367,070.1	(1,412,505.0)
	Цэвэр, бохир ус	864,250.5	799,838.9	(64,411.6)
	Байрны түрээс	594,138.2	586,138.2	(8,000.0)
Зөрүү	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,791,050.5	3,517,605.0	(1,273,445.5)
	Гэрэл цахилгаан	381,268.6	387,161.5	5,892.9
	Түлш халаалт	3,642,036.1	2,420,292.2	(1,221,743.9)
	Цэвэр, бохир ус	591,262.5	534,121.8	(57,140.7)
	Байрны түрээс	176,483.3	176,029.5	(453.8)

Эх сурвалж: /ТЕЗ-ийн 2023, 2024 оны санхүүгийн тайлангаас /

Төсөвт байгууллагууд гэрэл цахилгааны зардлыг 2023 онд 21.6 сая төгрөгөөр, 2024 онд 15.7 сая төгрөгөөр хэмнэсэн байна. Байгууллагууд цахилгаан эрчим хүчний хэрэглээнд тавих дотоодын хяналтыг сайжруулбал үүнээс илүү хэмнэлт хийх боломж байна.

Цэвэр, бохир усны зардлыг 2023 онд 7.2 сая төгрөгөөр, 2024 онд 64.4 сая төгрөгөөр хэмнэсэн дүнтэй байна. 2024 оны байдлаар цэвэр, бохир усны нэгдсэн системд холбогдсон аймгийн төвийн 78 төсөвт байгууллагад тоолуур тавьсан байна. Үүнээс 35 байгууллага буюу цэвэр, бохир усны хэрэглээ их аймгийн Нэгдсэн эмнэлэг, ерөнхий боловсролын сургууль, хүүхийн цэцэрлэг, 0165 дугаар анги зэрэг байгууллагуудын цэвэр, бохир усны төлбөр өндөр гардаг тул цэвэр, бохир усны батлагдсан төсвийг авдаг, цэвэр, бохир усны хэрэглээ бага 43 байгууллагын цэвэр, бохир усны төлбөрийг тоолуураар авдаг байна.

Түлш халаалтын зардлыг 2023 онд 190.7 сая төгрөгөөр, 2024 онд 1412.5 сая төгрөгөөр хэмнэсэн нь төсвийн төлөвлөлттэй холбоотой байна. Түлш халаалтын зардлын төсөв 2024 онд өмнөх оноос 39.8 хувиар, гүйцэтгэл 27.0 хувиар өссөн байна. Үүнд: Эрчим хүчний зохицуулах хороо, аймгийн Зохицуулах зөвлөлийн тогтоолоор аймаг, сумуудын хэрэглэгчдэд олгох дулааны эрчим хүчний тарифыг нэмэгдүүлж 2024 оны 01 дүгээр сарын 01-нээс мөрдсөн, 2024 онд шинээр ашиглалтад орсон сургууль, хүүхдийн цэцэрлэгийн байрны халаалтын зардал, Төрийн үйлчилгээний нэгдсэн төв шинээр ашиглалтад орсон, Нэгдсэн эмнэлэг болон өрхийн эмнэлэг тогтмол зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх болсон зэрэг нь нөлөөлжээ.

Хуулийн 15.2.2-т “нэгдсэн халаалтын системд холбогдсон барилга байгууламжийг хэмнэлтийн горимд тохируулах, тоолуур ашиглах” гэсэн заалтын хэрэгжилтийг шалгаж үзэхэд:

Баян-Өлгий аймгийн хэмжээнд 2023 онд 103, 2024 онд 106 байгууллага нэгдсэн халаалтын системд холбогдсон барилга байгууламжид үйл ажиллагаа явуулж ирсэн байна. 2024 оны түлш халаалтын зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийг судалж үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт-5		/ мянган төгрөг /		
Үзүүлэлт	тоо	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Босоо удирдлагатай байгууллага буюу улсын төсвийн байгууллага	34	2,388,779.8	2,374,190.4	14,589.4
Орон нутгийн байгууллага	72	10,382,560.7	9,285,867.4	1,096,693.3
Дүн	106	12,771,340.6	11,660,057.8	1,111,282.7

Эх сурвалжийг / <https://mof.gov.mn/> вэб сайт, байгууллагуудын санхүүгийн тайлан/

Түлш халаалтын зардлыг 2024 онд нэгдсэн халаалтын системд холбогдсон улсын төсвийн 34 байгууллага 14.6 сая төгрөгөөр, орон нутгийн 72 байгууллага 1,096.7 сая төгрөг хэмнэсэн байна.

Орон нутагт нэгдсэн халаалтын системд холбогдсон барилга байгууламжийг хэмнэлтийн горимд шилжүүлэх тохируулах, тоолуур ашиглах боломж бүрдээгүйгээс түлш халаалтын зардлыг батлагдсан төсвийн хуваарийг үндэслэн гэрээний дагуу төлж байна.

Аудитын явцад Өлгий сумын нэгдсэн халаалтад холбогдоогүй энгийн галлагаатай 4 сургуулийн 2023, 2024 оны түлш халаалтын зардлын төсвийн зарцуулалтыг судалж үзэхэд:

Хүснэгт-6		/ мянган төгрөг /				
Үзүүлэлт	2023 он			2024 он		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Өлгий сумын ЕБ-ын 7-р сургууль	26,200.0	26,200.0	-	36,000.0	36,000.0	-
Өлгий сумын ЕБ-ын 5-р сургууль	65,520.0	65,520.0	-	65,520.0	65,520.0	-
Өлгий сумын ЕБ-ын 9-р сургууль	26,880.0	26,880.0	-	36,960.0	36,951.0	(9.0)
Өлгий сумын ЕБ-ын 10-р сургууль	32,380.0	31,100.0	(1,280.0)	26,880.0	26,880.0	-
ДҮН	150,980.0	149,700.0	(1,280.0)	165,360.0	165,351.0	(9.0)

Эх сурвалжийг / <https://mof.gov.mn/> бэв сайтаас /

Өлгий сумын ерөнхий боловсролын 5, 7, 9, 10 дугаар сургуулиуд орон нутгийн төсвөөс санхүүжүүлж байгаа түлш халаалтын зардлын батлагдсан төсвийг гэрээ байгуулсан аж ахуйн нэгжүүдэд нүүрсний үнэд шилжүүлэн, галч нарын цалинг сургуулийн төсвөөс төлж байна. Үүнд:

- Өлгий сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургууль “ТММН” ХХК-д “халаалт түгээх, үйлчилгээг гүйцэтгэх гэрээ”-гээр 2023 онд 65.5 сая төгрөгийг, 2024 онд 65.5 сая төгрөгийг нүүрсний үнэд төлсөн ба төсвөөс 8

галчийн цалин, нийгмийн даатгалын шимтгэлд 2023 онд 60.0 сая, 2024 онд 91.5 сая төгрөг олгосон.

- Өлгий сумын ерөнхий боловсролын 7 дугаар сургууль “Өлгий таван гал” ХХК-д нүүрс худалдах, худалдан авах гэрээ”-гээр 2023 онд 26.2 сая төгрөгийг, 2024 онд 36.0 сая төгрөгийг нүүрсний үнэд шилжүүлсэн ба төсвөөс 5 галчийн цалин, нийгмийн даатгалын шимтгэлд 2023 онд 37.1 сая төгрөг, 2024 онд 38.0 сая төгрөг олгосон.
- Өлгий сумын ерөнхий боловсролын 9 дугаар сургууль “Нур хымыз” ХХК-д “Байгууллага аж ахуйн нэгжид дулааны эрчим хүч худалдах, худалдан авах гэрээ”-гээр 2023 онд 26.9 сая төгрөгийг, 2024 онд 36.9 сая төгрөгийг нүүрсний үнэд шилжүүлсэн ба төсвөөс 4 галчийн цалин, нийгмийн даатгалын шимтгэлд 2023 онд 27.7 сая төгрөг, 2024 онд 45.2 сая төгрөг олгосон.
- Өлгий сумын ерөнхий боловсролын 10 дугаар сургууль “Хүлэг ирээдүй” ХХК-д “Байгууллага аж ахуйн нэгжид дулааны эрчим хүч худалдах, худалдан авах гэрээ”-гээр 2023 онд 31.1 сая төгрөгийг, 2024 онд 26.9 сая төгрөгийг нүүрсний үнэд шилжүүлж, төсвөөс 4 галчийн цалин, нийгмийн даатгалын шимтгэлд 2023 онд 34.1 сая төгрөг, 2024 онд 48.5 сая төгрөг олгосон байна.

Төсвийн ерөнхий захирагчийн харьяа орон нутгийн байгууллагуудын Төрийн хэмнэлтийн тухай хуульд хэмнэхээр заасан зарим зардлын 2022-2024 оны санхүүгийн тайлангаас гарсан хэмнэлт, хэтрэлтийг хүснэгтээр харуулав.

Хүснэгт-7			/мянган төгрөг/						
Зардлын ангилал	2022 он			2023 он			2024 он		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Гэрэл цахилгаан	416,148.2	394,527.3	(21,620.9)	567,462.4	545,781.3	(21,681.1)	948,731.0	932,942.7	(15,788.3)
Түлш халаалт	6,229,692.3	6,163,726.8	(65,965.5)	9,137,539.0	8,946,777.9	(190,761.1)	12,779,575.1	11,367,070.1	(1,412,505.0)
Бичиг хэрэг	68,241.5	66,840.5	(1,401.0)	88,029.1	85,084.8	(2,944.3)	132,934.7	127,684.9	(5,249.8)
Тээвэр шатахуун	421,215.8	409,782.3	(11,433.5)	643,947.3	631,476.9	(12,470.4)	742,209.9	722,482.9	(19,727.0)
Шуудан холбоо	64,324.1	61,761.8	(2,562.3)	87,408.9	78,169.2	(9,239.7)	113,076.9	94,311.0	(18,765.9)
Нормын хувцас, зөөлөн эдлэл	12,925.6	12,464.6	(461.0)	19,338.9	18,957.0	(381.9)	42,584.8	37,930.3	(4,654.5)

Эх сурвалж: /Аудитын судалгаа/


Дээрх хүснэгтээс үзэхэд аймгийн Төсвийн ерөнхий захирагчийн харьяа орон нутгийн байгууллагуудын 2022-2024 оны гэрэл цахилгаан, түлш халаалт, бичиг хэрэг, тээвэр шатахуун, шуудан холбоо, нормын хувцас, зөөлөн эдлэл зэрэг зардлын батлагдсан төсөв төлөвлөснөөс бага гүйцэтгэлтэй гарсан байна.

Энэ нь нэг талаар орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлттэй холбоотой боловч Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлснээр төсвийн үрэлгэн зардал тодорхой хэмжээнд буурсан байна. Харин Төрийн хэмнэлтийн тухай хуулийг боловсронгуй болгох, хуулийг хэрэгжүүлсний үр дүнд бий болсон хэмнэгдсэн зардал, төсвийн үр ашиггүй зардлын бууралтыг дүгнэх шалгуур үзүүлэлтийг тодорхой болгох шаардлагатай байна.

Хуулийн 15.2.5-д “хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх” гэсэн заалтын хэрэгжилтийг шалгаж үзэхэд:

Аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын сүүлийн гурван жилийн өр төлбөрийн өсөлт, бууралтыг харьцуулж графикаар харуулав.

График-1



Эх сурвалж: /Аудитын судалгаа/

2024 оны өглөгийг 2022 онтой харьцуулж үзэхэд аймгийн ЦШСГазрын өглөг 1,233.9 сая төгрөгөөр, ТЕЗ-ийн харьяа бусад байгууллагууд 3,230.4 сая төгрөгөөр тус тус өсөж, "Суат" ХХК-ны өглөгийг 197.7 сая төгрөгөөр буурсан байна.

2024 оны жилийн эцсийн нийт өрийн 26.7 хувийг буюу 2,568.8 сая төгрөгийг урт хугацаатай өр, 73.3 хувийг буюу 7,036.4 сая төгрөгийг богино хугацаатай өглөг эзэлж байна.

Хүснэгт-8		/сая төгрөг/		
Байгууллагын нэр	2022 он	2023 он	2024 он	
ЦШСГазар	2,294.5	3,015.2	3,528.4	
Богино хугацаат өр төлбөр	157.9	878.6	1,391.8	
Урт хугацаат зээл	2,136.6	2,136.6	2,136.6	
"Суат" ХХК	1,258.8	1,270.8	1,061.1	
Богино хугацаат өр төлбөр	598.8	676.3	638.9	
Урт хугацаат зээл	660.0	594.5	422.2	
Жана өлкө ААТҮГазар	506.3	506.3	-	
Богино хугацаат өр төлбөр	368.3	368.3		
Урт хугацаат зээл	138.0	138.0		
Хала-өркени ААТҮГазар	22.4	24.3	20.4	
Богино хугацаат өр төлбөр	2.4	4.3	10.4	
Урт хугацаат зээл	20.0	20.0	10.0	
ОНХСангийн өглөг	10.3	1,146.5	721.1	
Бусад байгууллагуудын өглөг	1,018.5	587.5	3,427.3	
Орон нутгийн хөрөнгө оруулалтын өглөг	227.7	-	846.9	
ДҮН	5,338.6	6,550.5	9,605.2	

Эх сурвалж: /Аудитын судалгаа/

Хүснэгтээс үзэхэд 2024 онд өр төлбөр нийт дүнгээр 3,054.6 сая төгрөгөөр өсөхөд ЦШСГ-ын өглөг 513.0 сая төгрөгөөр, бусад байгууллагуудын өглөг 2,839.8 сая төгрөгөөр, орон нутгийн хөрөнгө оруулалтын өглөг 846.9 сая төгрөгөөр, аймгийн ОНХС-гийн өглөг 721.1 сая төгрөгөөр, Дэлүүн сумын ОНХС-ийн өглөг 876.9 сая төгрөгөөр, Улаанхус сумын ОНХС-ийн өглөг 182.5 сая төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна.

Өглөгтэй байгууллагууд өр төлбөр барагдуулах төлөвлөгөө боловсруулан батлуулж ажиллаагүй Төрийн хэмнэлтийн хуулийн 15.2.5-д “хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх” гэсэн заалтыг хэрэгжилт хангалтгүй байна.

Хуулийн 15.2.6-д “байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох” гэсэн заалтын хэрэгжилтийг шалгаж үзэхэд:

ЦШСГ-ын дээд шатны байгууллагаас 2022-2024 оны бүтэц орон тоог баталсан ямар нэгэн тогтоол, шийдвэр гараагүй байна. Тус газрын даргын бүтэц, орон тоо баталсан тушаалаар 2022 онд 89, 2023 онд 92, 2024 онд 94 орон тоогоор буюу жил бүр 2-3 орон тоог нэмэгдүүлж баталж ирсэн байна. Гүйцэтгэлээр 2022 онд 87, 2023 онд 89, 2024 онд 94 орон тоогоор орон тооны хязгаарт багтаан ажилласан.

“Суат” ХХК-ны ТУЗ-ын шийдвэрээр 2022 онд 74, 2023 онд 75, 2024 онд 76 орон тоогоор ажиллахаар баталсан байна. Гэвч 2022 оны 6 дугаар сараас эхэлж 12 дугаар сар хүртэл 78 хүнээр буюу 4 орон тоогоор, 2023 оны 1-р сараас 3 дугаар сар хүртэл 77 буюу 2 орон тоог илүү ажиллуулж Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.2-д “чиг үүрэг, орон тоог давхардуулан тогтоох”, 15.2.6-д “байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох” гэсэн заалтыг зөрчсөн байна. Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас 2025 оны 3 дугаар сард хийсэн шалгалтаар энэхүү зөрчилд албан шаардлага өгсөн байна.

Б. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТАЙ ХОЛБООТОЙ ХУУЛЬД ЗААСАН ЖУРМЫГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАСАН БОЛОВЧ ЦАХИМ ХУДАЛДАН АВАЛТЫН ЖУРМЫН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА

Б.1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийг хэрэгжүүлэн ажилласан байна

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1¹, 13.3², 13.4³, Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4⁴-д заасны дагуу улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд шинээр төсөл арга хэмжээ хэрэгжээгүй. 2024 онд 36 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр 29,574.9 сая төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 29,159.5 сая төгрөгийн өртөгтэй төсөл арга хэмжээг хэрэгжүүлж худалдан авах ажиллагааны үр дүнд 415.4 сая төгрөгийн хэмнэлт бий болсон ба Сангийн яамнаас гүйцэтгэлээр хэмнэлтийн 415.4 сая төгрөгийг дутуу санхүүжүүлсэн байна.

Аймгийн Худалдан авах ажиллагааны газраас 28,603.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 15,348.8 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 17 төсөл, арга хэмжээний (33 багц), аймгийн Онцгой байдлын газраас 900.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 900.0 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 1, Хөх сэрхийн нурууны УТХГ-аас 71.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 71.2 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 1 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулж, тендерийн баримт бичигт заасан шаардлага хангасан гүйцэтгэгч нарыг сонгон шалгаруулж, гэрээ байгуулсан байна.

Аймгийн Худалдан авах ажиллагааны газраас 17 төсөл арга хэмжээг 34 багцад хувааж тендер зарлаж, үүнээс 29 төсөл, арга хэмжээг нээлттэй, 1 төсөл, арга хэмжээг харьцуулалтын аргаар, 4 төсөл, арга хэмжээг ерөнхий гэрээний аргаар тендерийн журмыг баримтлан зохион байгуулсан байна. Үүнийг дараах хүснэгтээр харуулбал.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 26 төсөл арга хэмжээнээс 21 төсөл арга хэмжээний зураг төсөв хийгдсэн, Хууль зүй, дотоод хэргийн сайдын багцаас хэрэгжсэн Хилийн цэргийн 0285 дугаар ангийн алба хаагчдын орон сууцны засвар (Баян-Өлгий аймаг, Цагааннуур тосгон), Зам, тээврийн сайдын багцын 2, Эрчим хүчний сайдын багцын 2 төсөл, арга хэмжээний зураг төсөлгүй байна. (эрх шилжээгүй төсөл, арга хэмжээ бөгөөд гүйцэтгэгч нь орон нутгийн компани биш учраас аудитын явцад зураг төслийн талаар мэдээлэл байхгүй байна).

Аймгийн ИТХ-ын 2023 оны 197 дугаар тогтоолоор 2023 оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын их засварын ажилд 2,072.9 сая төгрөгийн төсөв

¹ 13.1.Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулахад дараах журмыг баримтална:

² 13.3.Улсын болон орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний жагсаалтад дараах зүйлсийг тусгахыг хориглоно:

³ 13.4.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад дараах зүйлсийг тусгахыг хориглоно:

⁴ 29.4.Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

батлагдаж, гүйцэтгэлээр 2,039.3 сая төгрөгийн өртөгтэй төсөл арга хэмжээг хэрэгжүүлж, худалдан авах ажиллагааны үр дүнд 33.5 сая төгрөгийн хэмнэлт бий болсон байна.

Аймгийн ИТХ-ын 2024 оны 262 дугаар тогтоолоор 2024 оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын их засварын ажилд 3,265.1 сая төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 3,153.2 сая төгрөгийн төсөв өртөгтэй төсөл арга хэмжээг хэрэгжүүлж, худалдан авах ажиллагааны үр дүнд 111.9 сая төгрөг,

Мөн бусад /барилга, тоног төхөөрөмж, худаг, гэрэлтүүлэг/ төсөл арга хэмжээнд 6,935.5 сая төгрөгийг төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 6,249.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл арга хэмжээг хэрэгжүүлж, худалдан авах ажиллагааны үр дүнд 330.7 сая төгрөгийн нийтдээ 2024 онд 442.6 сая төгрөгийн хэмнэлт бий болсон, 355.0 сая төгрөгийн 5 төсөл арга хэмжээ хэрэгжээгүй байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг орон нутгийн ерөнхий орлогын төрийн сан дахь 100020000910 тоот дансанд төвлөрүүлэх ёстой боловч орон нутгийн орлогын төлөвлөгөө тасарснаас болж 2023 онд 49.2 сая төгрөгөөр, 2024 онд 1,309.5 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу олгож, төсөл арга хэмжээний санхүүжилтийг гүйцэтгэлээр санхүүжүүлсэн байна.

Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг гэрээний үнийн дүнгээр санхүүжүүлж, хэмнэлт нь ерөнхий дансанд үлдсэн байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээг Аймгийн Худалдан авах ажиллагааны газраас 2023 онд 19 төсөл арга хэмжээ, 2024 онд 66 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны тендер зарлаж, тендерийн баримт бичигт заасан шаардлага хангасан гүйцэтгэгч нарыг сонгон шалгаруулж, гэрээ байгуулсан байна.

Хүснэгт-9				/мянган төгрөг/					
№	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөл арга хэмжээний тоо		Үүнээс:					
		Тоо	Дүн	Тендер зарласан		Шууд гэрээгээр худалдан авсан		Хэрэгжээгүй төсөл арга хэмжээ	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ОНХО-ын 2023 оны их засвар	36	2,072,800.0	19	1,776,900.00	17	295,900.0	0	0.0
2	ОНХО-ын 2024 оны их засвар	49	3,265,100.0	29	2,936,900.00	20	328,200.0	0	0.0
3	ОНХО-ын 2024 оны бусад ТАХ	144	6,935,535.0	37	4,846,500.00	102	1,734,000.0	5	355,000.0
	Дүн	29	12,273,435.0	85	9,560,300.0	139	2,358,100.0	5	355,000.0

Эх сурвалж: Аудитын судалгаа.

Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний зураг төсвийг Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4⁵, 29.2.6⁶, дахь заалт, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн

⁵ 29.4.Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

⁶ 291.2.2.барилга байгууламжийн хувьд Барилгын тухай хуулийн 4.1.30-д заасан зураг төсөл болон сүүлийн хоёр жилийн хугацаанд хийгдсэн магадлалаар баталгаажсан төсөвтэй байх;

хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 3.2.2.2-д заасны дагуу батлуулж, урсгал зардлын тооцооллыг хийж ажилласан байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2024 онд шууд гэрээгээр хэрэгжүүлэх 1,734.0 сая төгрөгийн 102 төсөл арга хэмжээний 537.0 сая төгрөгийн 31 төсөл арга хэмжээ нь тоног төхөөрөмж байна. Аймгийн Засаг даргын 2024 оны А/01, А/640 дугаар захирамжаар 537.0 сая төгрөгийн 31 төсөл арга хэмжээний 271.8 сая төгрөгийн 16 төсөл арга хэмжээг төсөв захирагчдад эрх шилжүүлсэн байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд одоо зэрэгцэн хийгдэж байгаа гүйцэтгэлийн аудитаар ТХтХуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх заалтын хэрэгжилтийг хамруулан шалгаж байгаа болно.

Б.2. Цахим худалдан авах ажиллагааг хуульд заасан журмын дагуу зохион байгуулж ажиллаагүй байна

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүнд хийсэн нийцлийн аудитаар төсөвт байгууллага, орон нутгийн өмчит үйлдвэрийн газрууд цахим худалдан авах ажиллагааг хуульд заасан журмын дагуу зохион байгуулсан эсэхийг шалгаж үзэхэд зарим байгууллага цахим худалдан авах ажиллагааг хуульд заасан журмын дагуу зохион байгуулаагүй байна.

Энэхүү нийцлийн аудитаар түүвэрт хамрагдсан 51 төсвийн байгууллагаас 11 байгууллага, 2023 оны санхүүгийн тайлангийн аудитад хамрагдсан 3 байгууллага, 2024 оны санхүүгийн тайлангийн аудитад хамрагдсан 17 байгууллага Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр 14.4, 14.5 заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Хүснэгт-10			/мянган төгрөг/					
Аудитын төрөл	Он	Байгууллагын тоо	Албан шаардлага		Зөвлөмж		Нийт дүн	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудит	2023	3	2	66,635.3	1	22,786.5	3	89,421.8
Санхүүгийн тайлангийн аудит	2024	17	7	208,489.0	10	125,308.3	17	333,797.3
Нийцлийн аудит	2024	11	11	399,299.5	0	0	11	399,299.5
Нийт		31	19	674,423.8	11	148,094.8	31	822,518.6

Эх сурвалж: Аудитаар илэрсэн зөрчлийн судалгаа

Сүүлийн хоёр жилд хийсэн аудитаар цахим худалдан авалттай холбоотой нийтдээ 822.5 сая төгрөгийн зөрчил илэрч 674.4 сая төгрөгийн 19 албан шаардлага, 148.1 сая төгрөгийн 11 зөвлөмж өгсөн байна.

- ✓ Төсвийн байгууллага, орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар 89.4 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 66.6 сая төгрөгийн 2 албан шаардлага, 22.8 сая төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.
- ✓ 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар 333.8 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 208.5 сая төгрөгийн 7 албан шаардлага, 125.3 сая төгрөгийн 10 зөвлөмж өгсөн.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүнд хийсэн нийцлийн аудитаар 51 байгууллагын үйл ажиллагаа, улс, орон нутгийн төсвийн хөрөнгө

оруулалтын 2023, 2024 оны хэрэгжилтийг хамруулан шалгаснаас 399.3 сая төгрөгийн зөрчил илэрч, зөрчил арилгах 11 албан шаардлага хүргүүлэв.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүнд хийсэн нийцлийн аудитаар цахим худалдан авалттай холбоотой илэрсэн зөрчлийг тодруулж үзвэл дараах байдалтай байна.Үүнд:

- Аймгийн Засаг даргын тамгын газар нь төсвийн хөрөнгөөр “Сайко инвест” ХХК-аас 2 ширхэг зөөврийн компьютер, 3 ширхэг ширээний компьютер, 3 ширхэг 3 үйлдэлтэй принтер бүгд 16.9 сая төгрөгийн, “Бектолхын” ХХК-аас 3.8 сая төгрөгийн нийтдээ 20.7 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг,
- Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал 2024 онд НИК ХХК-аас 16.1 сая төгрөгийн, Рысжан ХХК-аас 9.2 сая төгрөгийн нийтдээ 25.3 сая төгрөгийн шатахууныг,
- Өлгий сумын Засаг даргын тамгын газар 2023 онд 4.9 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 2024 онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлууаагүй, цахимаар сонгон шалгаруулалт хэрэгжүүлээгүй, Рысжан ХХК-аас 43.0 сая төгрөгийн шатахуун, тендер шалгаруулалтгүй “Ай ел нур” ХХК, “Сайко инвест” ХХК, “Худрет хоршоо”-ноос 57.7 сая төгрөгийн хөрөнгө, нийтдээ 100.7 сая төгрөгийн хөрөнгийг гэрээ шууд байгуулан худалдан авсан,
- Цахилгаан шугам сүлжээний газар “Мармара Өлгий” ХХК-аас 1 ширхэг HP принтер, “Сайко инвест” ХХК-аас 2 ширхэг DELL компьютер, 1 ширхэг 22 инчийн дэлгэц, 1 ширхэг HP принтер, “Киберком” ХХК-аас 3 ширхэг DELL компьютер, 2 ширхэг 24 инчийн дэлгэц, 1 ширхэг нөтбүүк компьютер, иргэнээс 1 ширхэг суурийн компьютер нийт 20.2 сая төгрөгийн тоног төхөөрөмж, “Өлгий ойл” ХХК-аас 2024 онд 60.4 сая төгрөгийн тээвэр шатахууныг гэрээ шууд байгуулан худалдан авсан,
- Өлгий сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль “АТ ресайкл” ХХК-аас 59.6 сая төгрөгийн, “Нарлаг ган хүлэмж” ХХК-аас 9.9 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг,
- Шүүх шинжилгээний хэлтэс “Бектолхын” ХХК-аас 2 ширхэг суурийн компьютер, 1 ширхэг принтер, “Эй Эн Ди Бест смарт технологи” ХХК-аас 1 ширхэг 75 инчийн ухаалаг дэлгэц 8.2 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг,
- Улаанхус сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал 2024 онд “Мармара Өлгий” ХХК-аас 6.6 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг,
- Дэлүүн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал 2024 онд “Бектолхын” ХХК-аас 1 ширхэг компьютерыг 3.4 сая төгрөгөөр, “Сайко инвест” ХХК-аас 2 ширхэг Notebook, 1 ширхэг компьютер, 2 ширхэг принтер дагалдах хэрэгслийг 18.9 сая төгрөгөөр, нийт 22.3 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг,
- Сагсай сумын Засаг даргын тамгын газар 2023 онд “Сайко инвест” ХХК-аас 10.2 сая төгрөгийн, 2024 онд “Сайко инвест” ХХК, “Асыл-Али” ХХК, “Бэст компьютер” ХХК-аас 13.1 сая төгрөгийн нийт 23.3 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг,

- Аймгийн Эрүүл мэндийн газар “Сайко инвест” ХХК-аас 1ш ширээний компьютер, 1ш 3 үйлдэлтэй принтер 6.4 сая төгрөгийн, Абай номын сангаас 3.8 сая төгрөгийн 1ш 3 үйлдэлтэй принтер, “Домогт-угсаа” ХХК-наас 4.8 сая төгрөгийн тавилга нийт 10.8 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг,
- Өлгий сумын ерөнхий боловсролын 7 дугаар сургууль 2023 онд “Гэрэг эдтек” ХХК-аас 1.5 сая төгрөгийн пос төхөөрөмж, хувь хүнээс 1.9 сая төгрөгийн 8 ш камер, 1 ш дэлгэц, 2024 онд “Өгөөж барс” ХХК-аас сурагчийн 17.1 сая төгрөгийн сандал ширээ, “Сайко инвест” ХХК-аас 4.7 сая төгрөгийн 6ш таблет, 0.6 сая төгрөгийн 1ш принтер нийт 25.8 сая төгрөгийн хөрөнгийг цахим дэлгүүрээс бусад газраас тус тус худалдан авсан байна.

Аудитаар илэрсэн зөрчлийн талаах судалгаа /цахим худалдан авалт хийгдээгүй хөрөнгийн ангилж харуулсан судалгаа /

Хүснэгт-11				/мянган төгрөг/	
Аудитын төрөл	Он	Тоног төхөөрөмж	Тавилга эд хогшил	Бусад	Нийт дүн
Санхүүгийн тайлангийн аудит	2022	350,233.9	15,319.5	0	365,553.40
Санхүүгийн тайлангийн аудит	2023	88,397.8	1,024.0	0	89,421.80
Санхүүгийн тайлангийн аудит	2024	314,351.4	19,445.9	0	333,797.30
Нийцлийн аудит	2024	201,913.0	10,868.3	186,518.2	399,299.50
Нийт		954,896.1	46,657.7	186,518.2	1,188,072.0

Эх сурвалж: Аудитаар илэрсэн зөрчлийн судалгаа

Дээрх хүснэгтээс харахад төрийн байгууллагуудын 2022-2024 онд цахим дэлгүүрээс бусад газраас худалдан авсан хөрөнгийн 80.3 хувийг компьютер, тоног төхөөрөмж, 3.9 хувийг тавилга эд хогшил, 15.7 хувийг бусад бараа, ажил, үйлчилгээ /ТХтХуулийн 14.5/ эзэлж байна.

Аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 зүйлийн хэрэгжилттэй холбоотой зөрчлийн шалтгааныг шалгагдагч байгууллагуудаас асууж тодруулахад цахим дэлгүүрт байршсан барааны үнэ орон нутагт худалдаалж байгаа бараанаас үнэтэй, цахим дэлгүүрт байгаа бараа нь чанаргүй, зарим барааны нэр төрөл, техникийн үзүүлэлт таарахгүй байсан зэргээс цахим дэлгүүрээс бусад газраас худалдан авсан гэсэн тайлбар хэлж байгаа нь үндэслэлгүй байна.

Энэ нь төрийн байгууллагуудын эрх бүхий албан тушаалтнууд хуулийн 14 зүйлийг бүрэн судлаагүй, цахим дэлгүүрээс барааг хэрхэн захиалж, худалдан авах талаар мэдлэг тааруу, нөгөө талаар ажлын хариуцлагатай холбоотой гэж үзэх үндэслэлтэй байна.

Аймгийн Худалдан авах газраас сумдын төсөвт байгууллагуудад “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн шинэчилсэн найруулгын талаар сургалт зохион байгуулсан боловч үр дүн багатай байна.

Аудитын дүнгээр аймгийн Худалдан авах ажиллагааны газарт Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйл цахим худалдан авалт, худалдан авалтыг

хуулийн дагуу зохион байгуулах талаар орон нутгийн төрийн байгууллагуудад сургалт зохион байгуулж, арга зүйн зөвлөгөө өгч ажиллах талаар зөвлөмж өгөв.

В. ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТАЛААР ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ ҮР ДҮН БАГАТАЙ БАЙНА

В.1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд дотоод аудитыг үр нөлөөтэй чиглүүлж ажиллаагүй байна

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 19.1-д “Энэ хуулийн хэрэгжилтэд төрийн аудитын байгууллага, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх байгууллага холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллана” гэж заасан.

Тус аудитын газраас санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд горим сорил хэрэгжүүлж шалгасан бөгөөд 2022 онд 709.5 сая төгрөгийн, 2023 онд 161.8 сая төгрөгийн, 2024 онд 400.1 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна.

Хүснэгт-12

/мянган төгрөг/

Аудитын төрөл	Зөрчсөн хуулийн заалт	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн		Нийт	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудит	6-р зүйл					1				1	-
	11-р зүйл	2	2,242.3	2	2,110.0					4	4,352.3
	12-р зүйл	1	195.0							1	195.0
	14-р зүйл			8	215,762.9	4	149,790.5			12	365,553.4
	15-р зүйл	4	2,206.3	14	158,429.9	1	5,616.0	1	173,199.2	20	339,451.4
2022 оны дүн		7	4,643.6	24	376,302.8	6	155,406.5	1	173,199.2	38	709,552.1
Санхүүгийн тайлангийн аудит	6-р зүйл					2				2	-
	11-р зүйл			1	3,432.4					1	3,432.4
	12-р зүйл			1	55,526.0					1	55,526.0
	14-р зүйл			2	66,635.3	1	22,786.5			3	89,421.8
	15-р зүйл	2	4,263.1	2	9,145.0					4	13,408.1
2023 оны дүн		2	4,263.1	6	134,738.7	3	22,786.5	-	-	11	161,788.3
Санхүүгийн тайлангийн аудит	5-р зүйл					1	2,570.3			1	2,570.3
	12-р зүйл	3	880.0							3	880.0
	14-р зүйл			7	208,489.0	10	125,308.3			17	333,797.3
	15-р зүйл			3	58,384.4	3	4,542.0			6	62,926.3
2024 оны дүн		3	880.0	10	266,873.4	14	132,420.6	-	-	27	400,173.9
Нийцлийн аудит	4-р зүйл			4	21,485.8					4	21,485.8
	8-р зүйл				5,000.0					0	5,000.0
	12-р зүйл			2	14,967.6					2	14,967.6
	14-р зүйл			8	399,299.5					8	399,299.5
	15-р зүйл	3	5,119.9	2	63,082.4					5	68,202.3
ДҮН		3	5,119.9	16	503,835.3	-	-	-	-	19	508,955.2
Нийт		15	14,906.58	40	777,914.8	23	310,613.6	1	173,199.2	79	1,276,634.2

Эх сурвалж: /Аудитын судалгаа/

Дээрх хүснэгтээс үзэхэд 2022-2024 онд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар 12 байгууллагад 9.8 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 23 байгууллагад 310.6 сая төгрөгийн зөвлөмж, 40 байгууллагад 777.9 сая төгрөгийн зөрчил арилгах албан шаардлага өгч, 173.2 сая төгрөгийн зөрчлийг хуулийн байгууллагад шалгуулахаар шилжүүлсэн байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт үр дүнд хийсэн нийцлийн аудитаар 3 байгууллагад 5.1 сая төгрөгийн нөхөн төлүүлэх акт тогтоож, 16 байгууллагад 503.8 сая төгрөгийн зөрчил арилгах албан шаардлага өгөв.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт үр дүнд хийсэн нийцлийн аудитаар илэрсэн зөрчлийг задалж үзэхэд:

- Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд баримтлах зарчмыг хэрэгжүүлж ажиллаагүй 4 байгууллагад 21.5 сая төгрөгийн,
- Тээврийн хэрэгслийн хязгаарлалтыг хэрэгжүүлээгүй 2 байгууллагад 1.3 сая төгрөгийн,
- Дүрэмт хувцасны хязгаарлалтыг хэрэгжүүлээгүй 1 байгууллагад 5.0 сая төгрөгийн,
- Бусад хангамжийн зардлыг хэмнэж ажиллаагүй 1 байгууллагад 13.7 сая төгрөгийн,
- Цахим худалдан авалтыг хуульд заасан журмын дагуу хэрэгжүүлээгүй 11 байгууллагад 399.3 сая төгрөгийн,
- Хэмнэлтийн бусад арга хэмжээг хуулийн дагуу зохион байгуулаагүй 6 байгууллагад 68.2 сая төгрөгийн зөрчлүүд байна.

Хуулийн 19.2-т “Төрийн болон орон нутгийн өмчит, түүний оролцоотой хуулийн этгээдийн удирдах албан тушаалтан энэ хуульд заасан хангамж, үйл ажиллагааны хязгаарлалтыг чанд мөрдөх ажилд хяналт тавьж, удирдах ажлыг хэрэгжүүлнэ” гэсэн заалтыг тодруулж үзэхэд:

“Суат” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 06 дугаар тогтоолоор тус аймагт зохион байгуулагдсан баруун бүсийн нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарын уулзалт зөвлөгөөн, спортын арга хэмжээнд 20.0 сая төгрөг зарцуулах шийдвэр гаргаж, гүйцэтгэлээр бэлэг дурсгал, шагнал, хүлээн авалтад 22.2 сая төгрөг зарцуулж, 2.2 сая төгрөгөөр хэтрүүлсэн зөрчилд төлбөрийн акт тогтоосон,

Энэхүү нийцлийн аудитаар “Суат” ХХК, ЦШСГ-ын 2023, 2024 оны үйл ажиллагаанд Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилтийг шалгахад хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.3, 4.2.6, 4.2.7, 15 дугаар зүйлийн 15.1.5 дах заалттай холбоотой зөрчлүүд илэрсэн.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас тус байгууллагуудын 2022-2024 оны үйл ажиллагаанд 2025 оны 3 дугаар сард хийсэн шалгалтаар илэрсэн дараах зөрчлүүдэд төлбөрийн акт, албан шаардлага өгсөн байна.Үүнд:

“Суат” ХХК 2022 онд бусад аймаг, нийслэлээс ирсэн НААҮ-ний салбарын зочид төлөөлөгчдийг хүлээн авах арга хэмжээний хоолны зардалд 8.9 сая төгрөг, бэлэг дурсгалын зүйл худалдаж авахад 7.4 сая төгрөг, шагнал, урамшуулал, хандивт 1.2 сая төгрөг, НААҮ-ний 91 жилийн ойн арга хэмжээнд 1.0 сая төгрөг, шинэ жилийн арга хэмжээнд 7.9 сая төгрөгийг бүгд 26.4 сая төгрөгийг зарцуулсан.

2023 онд шинэ жилийн арга хэмжээнд 8.3 сая төгрөг, бусад аймаг, нийслэлээс ирсэн НААҮ-ний салбарын зочид төлөөлөгчдийг хүлээж авах, цайллага, хүндэтгэлийн арга хэмжээнд 2.1 сая төгрөг бүгд 10.4 сая төгрөгийг зарцуулсан.

2024 онд Польш улсаас ирсэн хүмүүст 0.7 сая төгрөгийн гарын бэлэг, 1.1 сая төгрөгийн хоол, Ховд аймгийн НААҮ “Шим ус” байгууллагаас ирсэн хүмүүст 0.3 сая төгрөгийн хоол зэрэг бүгд 2.1 сая төгрөгийг зарцуулсан байна.

ЦШСГазар 2022 онд сахилгын шийтгэл ногдуулсан 13 ажилтанд 8.3 сая төгрөгийн шагналт цалин олгосон, Удирдах зөвлөлийн шийдвэргүйгээр тус газрын дарга нь 2023 онд 5.8 сая төгрөгийн, 2024 онд 8.1 сая төгрөгийн шагналт цалин, газрын дарга нь 2022 онд өөртөө тушаал гаргаж 4.0 сая төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж авсан зөрчил илэрсэн байна.

Ховд аймгаас ирсэн ажлын хэсгийг хүлээн авалтад 2023 онд 0.4 сая төгрөг, эрчим хүчний салбарын 100 жилийн ойн баярт 3.4 сая төгрөг, шинэ жилийн хүлээн авалтад 4.5 сая төгрөг, 2024 онд эрчим хүчний салбарын ойн өдөрлөгийг тохиолдуулан бүх ажилчдын амралт, зугаалга зохион байгуулахад 4.0 сая төгрөг, шинэ жилийн баярын цэнгүүнд 5.4 сая төгрөг бүгд 17.7 сая төгрөг зарцуулсан байна.

V.2. Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажилласан боловч үр дүн багатай байна

Засгийн Газрын 2022 оны “Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 203 дугаар хэрэгжилтийг шалгахад:

Аймгийн Засаг даргын захирамжаар 2022 онд 2 орлогч томилон ажиллуулж байсан ба Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлснээр хуулийн 5.2 дахь заалт, Засгийн Газрын 2022 оны “Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 203 дугаар тогтоолын 1.1 дэх заалтыг баримтлан аймгийн Засаг даргын орлогчийн илүү нэг орон тоог хасаж хууль, журмыг мөрдөж ажилласан байна.

Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 2022-2024 оны төсөл арга хэмжээний жагсаалтад хөшөө, дурсгал, үдэх хаалга хийх, техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй төсөл арга хэмжээг батлаагүй Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.3, 13.4 заалт, Засгийн Газрын 2022 оны “Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 203 дугаар тогтоолын 1.4 дэх заалтыг хэрэгжүүлэн ажилласан байна.

-Засгийн газрын 2022 оны “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 204 дүгээр тогтоолын хэрэгжилтийг шалгахад:

Автомашины хэрэглээг хуулиар хязгаарласантай холбогдуулан аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 117, 2023 оны 155, 210 дугаар тогтоолоор төсвийн байгууллагуудад ашиглагдаж байсан нийт 37 автотээврийн хэрэгслийг Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоолын дагуу татан төвлөрүүлж аймгийн ЗДТГ-ын хашаанд байршуулсан байна.

Үүнээс 20 авто машиныг дуудлагын автомашины зориулалтаар болон Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6.5-д заасан байгууллагуудад хуваарилсан, цаашид ашиглах боломжгүй гэж үзсэн 7 авто машиныг дуудлага худалдаагаар худалдахаар шийдвэрлэсэн, үлдсэн 10 автомашин татан төвлөрүүлэх шийдвэр

гарсан боловч хүлээлгэж өгөөгүй, шилжүүлсэн байгууллага нь авахаас татгалзсан дахин шийдвэр гаргахаар болсон байна. Тухайлбал:

- Цагааннуур тосгоны Ланд круизер 100, Орон нутгийн радио телевизийн суудлын автомашин, Аймгийн Эрүүл мэндийн газрын NISSAN, Patrol, УАЗ, 31519 зэрэг 4 машиныг татан төвлөрүүлэх шийдвэр гарсан боловч дээрх байгууллагууд татгалзаж хүлээлгэж өгөөгүй байна.
- Статистикийн хэлтсийн УАЗ-469 машин, Хөгжимт драмын театрын “УАЗ, 220692”, Алтай сумын Засаг даргын тамгын газрын “Ланд круизер 100”, Ногооннур сумын Засаг даргын тамгын газрын “Toyota, Land Cruiser” машин холбогдох шийдвэрээр шилжүүлсэн боловч, шилжүүлж авах байгууллагууд ашиглах боломжгүй гэсэн шалтгаанаар буцаасан тул дахин шийдвэр гаргуулахаар болсон байна.
- Баяннуур сумын Засаг даргын тамгын газрын УАЗ 31519 автомашиныг татан төвлөрүүлэлтийн шийдвэрийг үндэслэн хариуцагч байгууллага хүлээн авсан байна.
- Биеийн тамир спортын газрын “Старекс” автомашиныг 2025 онд дуудлага худалдалдаанд оруулахаар шийдвэрлэсэн ба шийдвэр биелэгдэх шатанд байна.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 117 тогтоолын дагуу 13 автомашиныг дуудлага худалдаагаар худалдсан, 3 автомашиныг балансаас балансад шилжүүлсэн, 4 автомашин тодорхой шалтгаанаар хуулийн байгууллагад шалгагдаж байгаа, 1 тээврийн хэрэгслийг тухайн байгууллага өгөхөөс татгалзаж ашиглаж байгаа, 1 автомашин балансаас балансад шилжүүлсэн боловч тухайн байгууллага ашиглах боломжгүй гэж аваагүй тул дахин худалдах шийдвэр гаргаж 2025 онд худалдахаар болсон байна. Үүнийг хариуцах байгууллагуудаар нь шалтгааныг тодруулж үзэхэд дараах байдалтай байна.

- ✓ Аймгийн Засаг даргын тамгын газрын 2003 онд ашиглалтад орсон чиргүүл, Бугат сумын Засаг даргын тамгын газрын “Бээжин жип”, Өлгий сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 1983 он ашиглалтад орсон Зил-130 машин, Улаанхус сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2007 онд ашиглалтад орсон “Тент” зэрэг 4 автомашин хуулийн байгууллагад шалгагдаж байна.
- ✓ Ахмадын хорооны Фургон машиныг өгөхөөс татгалзаж, тухайн байгууллагад ашиглаж байна.
- ✓ Алтай, Булган, Баяннуур сумын суудлын автомашиныг 2023 оны 149, 205 дугаар тогтоолоор Цагдаагийн газар, Мал эмнэлгийн газрын балансад шилжүүлсэн байна.

Орон нутгийн өмчийн газраас ирүүлсэн судалгаагаар 432.6 сая төгрөгийн балансын үнэлгээтэй 20 автомашиныг дуудлага худалдаанд оруулж, төсөвт 89.4 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас гарсан шийдвэрийн биелэлт хангагдахгүй 14 автомашин байна. Үүнд:

- Машинуудыг шилжүүлэхэд ашиглах боломжгүй болон бусад шалтгаанаар буцаагдсан, дахин шийдвэр гаргуулах 5 автомашин,

- Татан төвлөрүүлэх тогтоолыг биелүүлээгүй 4 байгууллагын 4 автомашин,
- Татан төвлөрүүлэх шийдвэр гарсан боловч цаашид шийдвэрлэх шаардлагатай 1 автомашин,
- Хуулийн байгууллагаар шалгагдаж байгаа 3 автомашин, нэг чиргүүл байна.

В.3. Шилэн дансны хуулийг зарим байгууллага бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Энэ хуулийн 3.1-д заасан этгээд Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь байршуулна” гэж заасан.

Тус аудитын газраас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2022-2024 онд хийсэн санхүүгийн тайлангийн аудит, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудитаар 154 байгууллагаас нийтдээ 39,401.6 сая төгрөгийн зөрчил илэрч 90 байгууллагад 22,412.6 сая төгрөгийн зөрчил арилгах албан шаардлага, 97 байгууллагад 13,192.3 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх талаар зөвлөмж, 5 байгууллагад 3,796.7 сая төгрөгийн зөрчилд холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн байна.

Хүснэгт-13

/Мянган төгрөг/

Аудитын төрөл	Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Нийт	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудит 2022 он	49	8,678,944.4	28	419,633.0	1	30,424.0	78	9,129,001.5
Санхүүгийн тайлангийн аудит 2023 он	20	5,877,133.3	30	3,090,489.6	2	3,720,812.3	52	12,688,435.2
Санхүүгийн тайлангийн аудит 2024 он	14	5,926,917.0	38	9,202,788.3	2	45,449.8	54	15,175,155.1
Нийцлийн аудит 2024 он	7	1,929,595.0	1	479,419.9			8	2,409,014.9
Нийт	90	22,412,589.8	97	13,192,330.8	5	3,796,686.1	192	39,401,606.7

Эх сурвалж: Аудитаар илэрсэн зөрчлийн судалгаа

Санхүүгийн тайлангийн аудитаар шилэн данстай холбоотой илэрсэн зөрчлийн мөнгөн дүн 2024 онд өмнөх оноос 2,486.7 сая төгрөгөөр өссөн дүнтэй харагдаж байгаа боловч зөрчил гаргасан байгууллагын тоо өмнөх оноос буурсан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудитаар түүвэрт хамруулсан 51 байгууллагын 8 байгууллагаас шилэн дансны мэдээллийг хугацаанд бүрэн байршуулаагүй 2,409.0 сая төгрөгийн зөрчил илэрч 1,929.6 сая төгрөгийн зөрчил арилгах 7 албан шаардлага, 479.4 сая төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.Үүнд:

✓ Аймгийн Хөгжимт драмын театр 2024 онд 620.8 сая төгрөгийн 44 гүйлгээг байршуулаагүй, шилэн дансны мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 61.4 хувьтай байна.

✓ Аймгийн Байгаль орчны газар 2023 онд 24.4 сая төгрөгийн 33 гүйлгээ, 2024 онд 25.5 сая төгрөгийн 24 гүйлгээг байршуулаагүй, шилэн дансны мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 61.9-69 хувьтай байна.

✓ Өлгий сумын 2 дугаар хүүхдийн цэцэрлэг 2023 онд 74.3 сая төгрөгийн 12 гүйлгээг, 2024 онд 104.3 сая төгрөгийн 12 гүйлгээг байршуулаагүй, шилэн дансны мэдээлсэн байдлын хэрэгжилтийн 72.7 хувьтай байна.

✓ Аймгийн Шүүх шинжилгээний хэлтэс 33.7 сая төгрөгийн 36 гүйлгээг, 2024 онд 68.2 сая төгрөгийн 49 гүйлгээг байршуулаагүй, шилэн дансны мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 65.0-81.4 хувьтай байна.

✓ Өлгий сумын ЕБ-ын 4 дүгээр сургууль 2024 онд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд нийт 1,937.6 сая төгрөгийн 104 гүйлгээг байршуулахаас 1,311.2 сая төгрөгийн 18 гүйлгээг байршуулаагүй, шилэн дансны мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 82.7 хувьтай байна.

✓ Өлгий сумын ЕБ-ын 5 дугаар сургууль шилэн дансны цахим хуудсанд 2024 онд 4,308.6 сая төгрөгийн 73 гүйлгээг байршуулахаас 494.2 сая төгрөгийн 27 гүйлгээг байршуулаагүй, шилэн дансны мэдээлсэн байдлын хэрэгжилт 63.0 хувьтай байна.

✓ Өлгий сумын ЕБ-ын 2 дугаар сургууль шилэн дансны цахим хуудсанд 2024 онд 3,687.9 сая төгрөгийн 418 гүйлгээний мэдээллийг байршуулахаас 479.4 сая төгрөгийн 48 гүйлгээг байршуулаагүй, шилэн дансны мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 88.5 хувьтай байна.

✓ Өлгий сумын ЗДТГазар шилэн дансны цахим хуудсанд 2024 онд 2,649.1 сая төгрөгийн 123 гүйлгээг байршуулахаас 125.8 сая төгрөгийн 27 гүйлгээг байршуулаагүй, шилэн дансны мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 78 хувьтай байна.

✓ Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал 2024 онд мэдээлэх ёстой 47.0 сая төгрөгийн 32 гүйлгээг байршуулаагүй, шилэн дансны мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 70.6 хувьтай байна.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас: (976) 7042-2483, Факс: (976) 7042-2483
Цахим шуудан: info@bo.gov.mn
Цахим хаяг: <http://bayan-olgi.gov.mn/>

2025.05.13 № 5-02/482
танай _____ -ны № _____ -т

**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

"Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт,
үр дүн" сэдвээр хийсэн нийцлийн аудитын тайлангийн
төсөлтэй танилцлаа.

Бидний зүгээс ямар нэгэн санал байхгүй болно.

САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА  Д. АНСАГАН



8325071046

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Орон нутгийн байгууллагууд хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллаагүй байна.
2. Төрийн цахим худалдан авалтын хэрэгжилт хангалтгүй байна.
3. Дотоод аудитыг үр нөлөөтэй хэрэгжүүлж ажиллаагүй байна

ЗӨВЛӨМЖ:

I.Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албад:

1. Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил жил бүр давтагдан гарч байгаа асуудалд дүгнэлт хийж, дотоод хяналтыг тогтмолжуулж, үр нөлөөг дээшлүүлэх;

II.Аймгийн Худалдан авах ажиллагааны газарт:

1.Төсвийн байгууллага, орон нутгийн өмчийн аж ахуйн нэгжүүдийг цахим худалдан авалт, худалдан авах ажиллагааг хуульд заасан журмын дагуу хэрэгжүүлэх талаар сургалт, арга зүйгээр хангаж ажиллах;

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5-т заасан хугацаанд буюу зөвлөмжийг хүлээн авснаас 30 хоногийн дотор зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

ҮАГ-т уламжлах санал :

1.Төрийн хэмнэлтийн тухай хуулийг боловсронгуй болгох саналыг холбогдох төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

2.Төрийн захиргааны байгууллагуудын үйлчилгээний орон тооны жишиг нормативыг боловсруулах талаар холбогдох яаманд санал хүргүүлэх;



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2025 оны 05 сарын 12 өдөр

Дугаар А/14

Өлгий

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 20 дугаар зүйлийн 20.4, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын хавсралтын 18 дугаар хэсгийн 18.9, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2023 оны "Эрх шилжүүлэх тухай" А/102 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтын 1-ийн 1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүн" сэдвээр хийсэн нийцлийн аудитын тайланг 1 дүгээр хавсралтаар, аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын жагсаалтыг 2 дугаар хавсралтаар баталгаажуулсугай.

2.Аудитын тайланг Эрсдэлийн удирдлагын газар, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргад тус тус хүргүүлсүгэй.

3.Аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг заасан хугацаанд ирүүлэхийг холбогдох байгууллагуудын удирдлагуудад зөвлөсүгэй.

4.Аудитын шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг ахлах аудитор (СНурлан)-д, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Х.Женисбек)-т тус тус даалгасугай.



Ж.АЙГҮЛ

ХАВСРАЛТ:1

Төрийн аудитын газраас 2022-2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар болон Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт үр дүнд хийгдсэн нийцлийн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл.

/Мянган төгрөг/

Зүйл заалтууд		2022		2023 он		2024 он		Нийт	
		Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн
Санхүүгийн 2022-2024 оны тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	4-р зүйл "Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд баримтлах зарчмыг хэрэгжүүлж ажилласан эсэх"	-	-	-	-	-	-	-	-
	5-р зүйл "Тэргүүн дэд, дэд, орлогч дарга ажиллуулсан эсэх"	-	-	-	-	1	2,570.3	1	2,570.3
	6-р зүйл "Тээврийн хэрэгслийн хязгаарлалтыг хэрэгжүүлж ажилласан эсэх"	1	-	2	-	-	-	3	-
	8-р зүйл "Дүрэмт хувцасны хязгаарлалтыг хэрэгжүүлсэн эсэх"	-	-	-	-	-	-	-	-
	9-р зүйл "Албан томилолтын зардлыг хязгаарласан эсэх"	-	-	-	-	-	-	-	-
	10-р зүйл "Цалин хөлсний нийтлэг жишигийг тогтоосон эсэх"	-	-	-	-	-	-	-	-
	11-р зүйл "Нэг удаагийн тэтгэмж давхардуулан олгосон эсэх"	4	4,352.3	1	3,432.4	-	-	5	7,784.7
	12-р зүйл "Бусад хангамжийн зардлыг хэмнэсэн эсэх"	1	195.0	1	55,526.0	3	880.0	5	56,601.0
	13-р зүйл "Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хуулийн дагуу зохион байгуулсан эсэх"	-	-	-	-	-	-	-	-
	14-р зүйл "Цахим худалдан авалт"	12	365,553.4	3	89,421.8	17	333,797.3	32	788,772.5
	15-р зүйл "Хэмнэлтийн бусад арга хэмжээг хуулийн дагуу зохион байгуулсан эсэх"	20	339,451.3	4	13,408.1	6	62,926.3	30	415,785.7
	Хуулийн 4-12 дугаар заалтын хэрэгжилттэй холбоотой илэрсэн зөрчлийн дүн	38	709,552.0	11	161,788.3	27	400,173.9	76	1,271,514.2
	20-р зүйл "Шилэн дансаны тухай хуульд заасан мэдээллийг ил тод байршуулсан эсэх"	78	9,129,001.5	52	12,688,435.2	55	15,175,155.1	185	36,992,591.8
Дүн		116	9,838,553.5	63	12,850,223.5	82	15,575,329.0	261	38,264,106.0
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт үр дүнд хийгдсэн нийцлийн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	4-р зүйл "Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд баримтлах зарчмыг хэрэгжүүлж ажилласан эсэх"					4	21,485.8	4	21,485.8
	5-р зүйл "Тэргүүн дэд, дэд, орлогч дарга ажиллуулсан эсэх"							-	-
	6-р зүйл "Тээврийн хэрэгслийн хязгаарлалтыг хэрэгжүүлж ажилласан эсэх"					2	1,287.6	2	1,287.6
	8-р зүйл "Дүрэмт хувцасны хязгаарлалтыг хэрэгжүүлсэн эсэх"					-	5,000.0	-	5,000.0
	9-р зүйл "Албан томилолтын зардлыг хязгаарласан эсэх"							-	-
	10-р зүйл "Цалин хөлсний нийтлэг жишигийг тогтоосон эсэх"							-	-
	11-р зүйл "Нэг удаагийн тэтгэмж давхардуулан олгосон эсэх"							-	-
	12-р зүйл "Бусад хангамжийн зардлыг хэмнэсэн эсэх"					1	13,680.0	1	13,680.0
	13-р зүйл "Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хуулийн дагуу зохион байгуулсан эсэх"							-	-
	14-р зүйл "Цахим худалдан авалт"					8	399,299.5	8	399,299.5
	15-р зүйл "Хэмнэлтийн бусад арга хэмжээг хуулийн дагуу зохион байгуулсан эсэх"					5	68,202.3	5	68,202.3
	Хуулийн 4-12 дугаар заалтын хэрэгжилттэй холбоотой илэрсэн зөрчлийн дүн					20	508,955.2	20	508,955.2
	20-р зүйл "Шилэн дансаны тухай хуульд заасан мэдээллийг ил тод байршуулсан эсэх"					8	2,409,014.9	8	2,409,014.9
Дүн		-	-	-	-	28	2,917,970.1	28	2,917,970.1
НИЙТ ДҮН		116	9,838,553.5	63	12,850,223.5	110	18,493,299.1	289	41,182,076.1